

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/173/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод хот 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК

Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан	12
2.6 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
2.7 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	17
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	17
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	19
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	19
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	20
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	22
4.1 Ерөнхий зүйл.....	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	25
4.5.1 Завсрын аудитын талаар	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	25
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	26
5.1 Төлбөрийн акт	26
5.2 Албан шаардлага	27
5.3 Зөвлөмж.....	27
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт Стандарт
ХНХСайд	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ЭМГ	Эрүүл мэндийн газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ХНХ	Хөдөлмөр нийгмийн хамгаалал
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023. 02. 24 № 01/169
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн байх мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Арилжааны банканд касс, түрээсийн орлогын 2 харилцах данс нээж 1,420.0 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй;
- Урсгал зардлаас халаалтын зардалд 2,835.1 мянган төгрөгийн, цахилгааны зардалд 966.2 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсан;
- Худалдан авсан хөрөнгө, материалын дүн, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн төлбөрийн баримтын дүнгээс 7 иргэн, байгууллага 20,146.8 мянган төгрөгөөр илүү, 10 иргэн, байгууллага 7,560.2 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн;
- Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн А/29 дугаар "Эд хөрөнгийн тооллого хийх тухай" тушаалыг хэрэгжүүлээгүй, 63,662.0 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй, тооцоог бодоогүй;

19020353

- Орон нутгийн нэмэгдлийг 1 ажилтанд 222.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 12 дугаар зүйлийн 12.1.11, 35.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дугаар заалтууд, УСНББОУС 7, УСБНЗСТОУБ-ын 3.10-т заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам”-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 60,702.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн суурь, бодлогын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 удирдах, 17 гүйцэтгэх, 4 үйлчилгээний ажилтан, нийт 22 орон тоо батлагдсанаас 1 удирдах, 13 гүйцэтгэх, 4 үйлчилгээний албан тушаалд ажиллаж, батлагдсан бүтэц орон тооноос нийт 4 ажилтан дутуу ажилласан.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93,2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	218,809,625.93	192,772,031.93
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	5,578,065.46	60,702,137.05
312	Банканд байгаа бэлэн мөнгө	5,578,065.46	60,702,137.05
3121	Төгрөг	5,578,065.46	60,702,137.05
31211	Төрийн сангийн харилцах	5,369,618.46	59,282,137.05
31213	Арилжааны банкин дахь харилцах	-	1,420,000.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	208,447.00	-
33	АВЛАГА	120,094,438.10	454,390.10
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	11,948.00	453,300.00
335	Бусад авлага	120,082,490.10	1,090.10
3351	Байгууллагаас авах авлага	120,081,490.10	90.10
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,000.00	1,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	93,137,122.37	131,615,504.78
351	Түүхий эд материал	75,232,178.22	104,495,191.80
35110	Тусгай зориулалттай материал	30,119,954.12	45,544,435.24
35130	Эм боох материал	45,112,224.10	58,950,756.56
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,064,979.20	4,711,206.90
354	Хангамжийн материал	13,839,964.95	22,409,106.08
35410	Бичиг хэргийн материал	787,690.00	1,032,900.00
35420	Аж ахуйн материал	5,457,564.08	4,946,156.08
35430	Сэлбэг хэрэгсэл	5,020,950.00	12,228,950.00
35440	Түлш шатах тослох материал	542,270.87	2,500.00
35460	Хүнсний материал	413,990.00	1,513,600.00
35470	Бусад хангамжийн материал	1,617,500.00	2,685,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,680,956,718.04	1,791,508,685.11
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,680,956,718.04	1,791,508,685.11
392	Биет хөрөнгө	1,666,762,718.04	1,777,314,685.11
39201	Барилга, байгууламж	1,589,865,390.00	1,589,865,390.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(38,826,606.89)	(71,213,244.53)
39203	Авто тээврийн хэрэгсэл	89,575,000.00	159,575,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(43,320,000.00)	(53,574,999.96)
39205	Машин, тоног төхөөрөмж	141,007,889.75	196,043,722.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(81,625,296.53)	(85,766,245.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,902,241.99	46,059,654.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,784,850.28)	(9,351,542.72)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,460,000.00	6,460,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,292,000.04)
39217	Номын фонд	508,950.00	508,950.00
393	Биет бус хөрөнгө	14,194,000.00	14,194,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,394,000.00	14,394,000.00
39304	Хасагдуулаг	(200,000.00)	(200,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,899,766,343.97	1,984,280,717.04
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	36,743,520.91	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	36,743,520.91	-
413	Өглөг	36,743,520.91	-
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	679,500.91	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	28,074,020.00	-
4136	Бусад өглөг	7,990,000.00	-

Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41361	Байгууллагад төлөх өглөг	7,990,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,863,022,823.06	1,984,280,716.94
51	Засгийн газрын хувь оролцоо	1,863,022,823.06	1,984,280,716.94
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	218,103,311.04	218,103,311.04
51101	Өмч: -Төрийн өмч	218,103,311.04	218,103,311.04
512	Хуримтлагдсан үр дүн	1,394,152,392.18	1,515,410,286.06
51210	Өмнөх үеийн үр дүн	1,394,152,392.18	1,394,152,392.18
51220	Тайлант үеийн үр дүн	-	121,257,893.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	250,767,119.84	250,767,119.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,899,766,343.97	1,984,280,717.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	296,154,478.71	680,958,928.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97,502,210.61	152,727,828.64
120	Нийтлэг татварын бус орлого	97,502,210.61	150,416,328.64
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	97,502,210.61	148,996,328.64
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	97,502,210.61	148,996,328.64
120009	Бусад орлого	-	1,420,000.00
122	Тусламжийн орлого	-	2,311,500.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	2,311,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	37,542,468.10	528,231,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	161,109,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,540,138.10	250,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	10,540,138.10	250,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,316,300.00	59,561,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,316,300.00	59,561,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	6,686,030.00	468,420,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас	6,686,030.00	468,420,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	243,844,755.40	559,701,034.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	243,844,755.40	559,701,034.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	243,844,755.40	553,208,119.30
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	116,094,532.00	270,450,395.60
210101	Цалин	116,094,532.00	186,033,180.44
210102	Нэмэгдэл цалин	-	57,749,095.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,660,000.00
210104	Урамшуулал	-	23,008,119.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,104,052.54	36,150,678.54
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	11,758,294.55	25,946,513.43
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,233,073.64	2,847,304.05
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	946,138.71	2,177,043.20

Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	196,959.24	417,364.71
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,969,586.40	4,762,453.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,852,115.00	53,987,569.00
210301	Гэрэл цахилгааны зардал	1,972,115.00	6,225,014.00
210302	Түлш, халаалтын зардал	11,880,000.00	47,762,555.00
2104	Хангамж, бараа материалын зардал	75,063,376.06	41,396,255.87
210401	Бичиг хэргийн материал	442,950.00	1,945,290.00
210402	Тээвэр, шатахууны зардал	8,715,203.00	27,186,099.87
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	-	671,500.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	715,000.00	2,356,998.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	65,190,223.06	9,236,368.00
2105	Нормативт зардал	8,754,372.79	71,417,519.74
210501	Эм	5,414,937.79	62,431,529.74
210502	Хоол	3,339,435.00	8,985,990.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,411,350.00	11,022,933.97
210601	Багаж хэрэгсэл	-	386,999.97
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,353,050.00	4,117,800.00
210604	Урсгал засвар	58,300.00	6,518,134.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,500,000.00
210702	Дотоод томилолтын зардал	-	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	798,850.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	798,850.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,766,107.01	67,282,766.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,313,500.00	4,987,230.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,452,607.01	62,295,536.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	6,492,915.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	17,000.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	17,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	6,475,915.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,475,915.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	52,309,723.31	121,257,893.88
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	52,309,723.31	121,257,893.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	544,412,003.10	649,732,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,420,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,420,000.00
120009	Бусад орлого	-	1,420,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	544,412,003.10	648,312,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	328,591,255.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	154,843,738.10	120,331,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	154,843,738.10	250,000.00
131107	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих - Нэмэлт	-	120,081,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,461,000.00	59,561,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	48,461,000.00	59,561,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,516,010.00	468,420,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,516,010.00	468,420,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	538,797,087.64	549,943,978.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	538,797,087.64	549,943,978.41
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	520,427,634.64	543,468,062.95
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	296,936,935.00	270,891,747.40
210101	Үндсэн цалин	192,687,684.00	186,702,394.34
210102	Нэмэгдэл	63,219,438.00	57,521,233.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,029,813.00	3,660,000.00
210104	Үр дүнгийн урамшуулал	-	23,008,119.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,904,359.54	36,830,179.55
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	23,899,302.21	26,626,014.44
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,021,917.11	2,847,304.05
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,015,780.06	2,177,043.20
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	458,741.86	417,364.71
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,508,618.30	4,762,453.15
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	30,249,947.00	53,987,569.00
210301	Гэрэл цахилгааны зардал	3,604,592.00	6,225,014.00
210302	Түлш, халаалтын зардал	26,645,355.00	47,762,555.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,068,978.50	32,325,627.00
210401	Бичиг хэрэг	3,216,697.00	2,650,800.00
210402	Тээвэр, шатахуун	19,012,281.50	26,646,329.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	615,000.00	671,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,225,000.00	2,356,998.00
2105	Нормативт зардал	67,719,833.00	120,982,276.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	61,974,038.00	106,560,676.00

Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	5,745,795.00	9,455,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	4,966,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,038,750.00	21,963,434.00
210601	Багаж техник хэрэгсэл	5,029,150.00	3,478,500.00
210602	Тавилга	-	2,750,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	3,120,000.00	4,117,800.00
210604	Урсгал засвар	1,889,600.00	11,617,134.00
2107	Томилолт, зочны зардал	369,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	369,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,139,831.60	4,987,230.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,139,831.60	4,987,230.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,369,453.00	6,475,915.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,008,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,008,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,361,453.00	6,475,915.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,361,453.00	6,475,915.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,614,915.46	99,788,521.59
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	36,850.00	44,664,450.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,850.00	44,664,450.00
2200	Дотоод эх үүсвэрээр	36,850.00	44,664,450.00
223001	Бусад хөрөнгө	36,850.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	44,664,450.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(36,850.00)	(44,664,450.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ЗАРДЛЫН ДҮН	108,000.00	-
	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	108,000.00	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(108,000.00)	-
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	ДАНС	511	51300	51210+51220	/төгрөгөөр/
C01	2021 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	203,909,311.04	116,128,601.07	(73,488,092.74)	246,549,819.37
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	203,909,311.04	116,128,601.07	(73,488,092.74)	246,549,819.37
C04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
C05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	9,900,312.00	9,900,312.00
C08	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	218,103,311.04	250,767,119.84	1,394,152,392.18	1,863,022,823.06
D01	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	218,103,311.04	250,767,119.84	1,394,152,392.18	1,863,022,823.06
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	218,103,311.04	250,767,119.84	1,394,152,392.18	1,863,022,823.06
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	121,257,893.88	121,257,893.88
D09	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	218,103,311.04	250,767,119.84	1,515,410,286.06	1,984,280,716.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,578,065.46	(5,578,065.46)	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	597,671,900.00	588,132,512.95	9,539,387.05	98.4
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	597,671,900.00	588,132,512.95	9,539,387.05	98.4
210	Бараа, үйлчилгээний зардал	597,671,900.00	588,132,512.95	9,539,387.05	98.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	278,317,500.00	270,891,747.40	7,425,752.60	97.3
210101	Үндсэн цалин	171,646,000.00	186,702,394.34	(15,056,394.34)	108.8
210102	Нэмэгдэл	72,705,000.00	57,521,233.38	15,183,766.62	79.1
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	12,069,500.00	3,660,000.00	8,409,500.00	30.3
210104	Урамшуулал	21,897,000.00	23,008,119.68	(1,111,119.68)	105.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,702,200.00	36,830,179.55	(127,979.55)	100.3
210201	Тэтгэврийн даатгал	25,597,500.00	26,626,014.44	(1,028,514.44)	104.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,776,100.00	2,847,304.05	(71,204.05)	102.6
210203	ҮОМШӨ ний даатгал	2,221,000.00	2,177,043.20	43,956.80	98.0
210204	Ажилгүйдлийн даатгал	555,300.00	417,364.71	137,935.29	75.2
210205	Эрүүл мэндийн даатгал	5,552,300.00	4,762,453.15	789,846.85	85.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,861,000.00	53,987,569.00	(1,126,569.00)	102.1
210301	Гэрэл цахилгаан	6,439,000.00	6,225,014.00	213,986.00	96.7
210302	Түлш, халаалт	46,197,000.00	47,762,555.00	(1,565,555.00)	103.4
210303	Цэвэр, бохир ус	225,000.00	-	225,000.00	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	29,871,900.00	32,325,627.00	(2,453,727.00)	108.2
210401	Бичиг хэрэг	2,460,300.00	2,650,800.00	(190,500.00)	107.7
210402	Тээвэр (шатахуун)	23,411,600.00	26,646,329.00	(3,234,729.00)	113.8
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	671,500.00	828,500.00	44.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,356,998.00	143,002.00	94.3
2105	Нормативт зардал	124,287,300.00	120,982,276.00	3,305,024.00	97.3
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	109,814,000.00	106,560,676.00	3,253,324.00	97.0
210502	Хоол, хүнс	9,473,300.00	9,455,600.00	17,700.00	99.8
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	5,000,000.00	4,966,000.00	34,000.00	99.3
2106	Эд хогшил худалдан авах	67,952,000.00	66,627,884.00	1,324,116.00	98.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,806,500.00	25,799,200.00	7,300.00	100.0
210602	Тавилга	25,634,700.00	25,093,750.00	540,950.00	97.9

Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	3,740,800.00	4,117,800.00	(377,000.00)	110.1
210604	Урсгал засвар	12,770,000.00	11,617,134.00	1,152,866.00	91.0
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	6,180,000.00	4,987,230.00	1,192,770.00	80.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,180,000.00	4,987,230.00	1,192,770.00	80.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	598,751,900.00	528,231,100.00	70,520,800.00	88.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,561,000.00	59,561,000.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	59,561,000.00	59,561,000.00	-	100.0
1340	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	419,048,300.00	468,420,100.00	(49,371,800.00)	111.8
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	419,048,300.00	468,420,100.00	(49,371,800.00)	111.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	120,142,600.00	-	120,142,600.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,142,600.00	-	120,142,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	250,000.00	(250,000.00)	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	250,000.00	(250,000.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,578,065.46	(5,578,065.46)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	60,702,137.05	(60,702,137.05)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22	18	4	81.8
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17	13	4	76.5
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	3522	3522	-	100.0

2.6 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	539,190,900.00	529,677,809.95	9,513,090.05	98.2
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	539,190,900.00	529,677,809.95	9,513,090.05	98.2
210	Бараа, үйлчилгээний зардал	539,190,900.00	529,677,809.95	9,513,090.05	98.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	278,317,500.00	270,891,747.40	7,425,752.60	97.3
210101	Үндсэн цалин	171,646,000.00	186,702,394.34	(15,056,394.34)	108.8
210102	Нэмэгдэл	72,705,000.00	57,521,233.38	15,183,766.62	79.1
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	12,069,500.00	3,660,000.00	8,409,500.00	30.3
210104	Урамшуулал	21,897,000.00	23,008,119.68	(1,111,119.68)	105.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,702,200.00	36,830,179.55	(127,979.55)	100.3
210201	Тэтгэврийн даатгал	25,597,500.00	26,626,014.44	(1,028,514.44)	104.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,776,100.00	2,847,304.05	(71,204.05)	102.6
210203	ҮОМШӨ ний даатгал	2,221,000.00	2,177,043.20	43,956.80	98.0
210204	Ажилгүйдлийн даатгал	555,300.00	417,364.71	137,935.29	75.2
210205	Эрүүл мэндийн даатгал	5,552,300.00	4,762,453.15	789,846.85	85.8
2104	Хангамж, бараа материалын зардал	29,871,900.00	32,325,627.00	(2,453,727.00)	108.2
210401	Бичиг хэрэг	2,460,300.00	2,650,800.00	(190,500.00)	107.7
210402	Тээвэр (шатахуун)	23,411,600.00	26,646,329.00	(3,234,729.00)	113.8
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	671,500.00	828,500.00	44.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,356,998.00	143,002.00	94.3
2105	Нормативт зардал	124,287,300.00	120,982,276.00	3,305,024.00	97.3
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	109,814,000.00	106,560,676.00	3,253,324.00	97.0
210502	Хоол, хүнс	9,473,300.00	9,455,600.00	17,700.00	99.8
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	5,000,000.00	4,966,000.00	34,000.00	99.3
2106	Эд хогшил худалдан авах	62,332,000.00	62,160,750.00	171,250.00	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,806,500.00	25,799,200.00	7,300.00	100.0
210602	Тавилга	25,634,700.00	25,093,750.00	540,950.00	97.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	3,740,800.00	4,117,800.00	(377,000.00)	110.1
210604	Урсгал засвар	7,150,000.00	7,150,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,500,000.00	-	100.0

Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2201	Бараа үйлчилгээний бусад зардал	6,180,000.00	4,987,230.00	1,192,770.00	80.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,180,000.00	4,987,230.00	1,192,770.00	80.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	539,190,900.00	468,670,100.00	70,520,800.00	86.9
1340	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	419,048,300.00	468,420,100.00	(49,371,800.00)	111.8
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	419,048,300.00	468,420,100.00	(49,371,800.00)	111.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	120,142,600.00	-	120,142,600.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,142,600.00	-	120,142,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	250,000.00	(250,000.00)	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	250,000.00	(250,000.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	60,702,137.05	(60,702,137.05)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22	18	4	81.8
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17	13	4	76.5
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	3522	3522	-	100.0

2.7 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,369,618.46	(5,369,618.46)	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,481,000.00	58,454,703.00	26,297.00	100.0
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	58,481,000.00	58,454,703.00	26,297.00	100.0
210	Бараа, үйлчилгээний зардал	58,481,000.00	58,454,703.00	26,297.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,861,000.00	53,987,569.00	(1,126,569.00)	102.1
210301	Гэрэл цахилгаан	6,439,000.00	6,225,014.00	213,986.00	96.7
210302	Түлш, халаалт	46,197,000.00	47,762,555.00	(1,565,555.00)	103.4
210303	Цэвэр, бохир ус	225,000.00	-	225,000.00	-
2106	Эд хогшил худалдан авах	5,620,000.00	4,467,134.00	1,152,866.00	79.5
210604	Урсгал засвар	5,620,000.00	4,467,134.00	1,152,866.00	79.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,561,000.00	59,561,000.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,561,000.00	59,561,000.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	59,561,000.00	59,561,000.00	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,369,618.46	(5,369,618.46)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22	18	4	81.8
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17	13	4	76.5
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	3522	3522	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Иргэдийг оношилгоо, эмчилгээ үйлчилгээний баталгаат тусламжаар хангах, эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад оршино”, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлд:

- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2, 16.7-д заасан үндсэн чиг үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ;
- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;
- Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх;
- Сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх;

Түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх; гэж тодорхойлсон ба 2022 онд” Эмнэлгийн тусламж үйлчилгээг аюулгүй, чанар хүртээмжтэй хүргэж, өвчлөл эндэгдлийг бууруулах” зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 –д “Хот суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г үзүүлдэг Эрүүл мэндийн сайдын харьяа байгууллага юм.

Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн.
- Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль /2022 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр батлагдсан./
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ”;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол,
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”;
- “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн А/49 дүгээр тогтоол;

Эмнэлэг, эрүүл мэндийн салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын сайд, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс гаргаж мөрдүүлсэн байна. Үүнд:

- “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ны өдрийн 107 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт”-аар “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ”-г тогтоосон;

- “Эмнэлэг, эрүүл мэндийн салбарт 2022 онд Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай, Цусны донорын тухай, Тамхины тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан ажилласан байна;
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр “Журам батлах тухай” тушаал;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай” 06 дугаар тогтоол;
- “Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалт, эм олгох үйл ажиллагааг зохицуулах журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2022 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн А/407 дугаар тушаал;
- ЭМСайдын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/216 дугаар тушаалаар “Төрийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй үйлчилгээний жагсаалтыг баталсан;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 01 дүгээр тогтоол;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2022 оны 05 дугаар тогтоол;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2022 оны 09, 14 дүгээр тогтоол;
- Сангийн сайд, ЭМС-ын 2022 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 49, А/118 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийн жишиг жагсаалтыг, хоёрдугаар хавсралтаар Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журмыг баталсан;
- ЭМС-ын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/216 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж үйлчилгээний журам”, хоёрдугаар хавсралтаар “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”-ыг тус тус баталсан;
- ЭМДҮЗ-ийн 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын 2-т “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн үйлчилгээний нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн үлдэгдэл 20 хувь, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх хэвтүүлэн эмчлэх, яаралтай тусламж, түргэн тусламж, шүд, амны хөндийн тусламж үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны 05 болон 06 дугаар сарын статистик тоон мэдээлэл дээр үндэслэн хяналт тавьж санхүүжүүлэх;
- ЭМДҮЗ-ийн 2022 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн 14 дүгээр тогтоолын 2-т “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн үйлчилгээний нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн үлдэгдэл 20 хувь, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх хэвтүүлэн эмчлэх, яаралтай тусламж, түргэн тусламж, шүд, амны хөндийн тусламж үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны 7, 8, 9, 10 дугаар сарын статистик тоон мэдээлэл дээр үндэслэн хяналт тавьж санхүүжүүлэх;
- Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал;

Байгууллагын дотоод хяналтын талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 3 дугаар сарын 23-ний өдрийн А/13 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар дотоод хяналтын багийн бүрэлдэхүүнийг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилж, 2 дугаар хавсралтаар “Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын журам”-ыг баталсан байна. “Дотоод хяналт шалгалтын зорилго нь Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, ЭМС-ын

тушаалд заавал мөрдөх стандарт, клиникийн удирдамж, байгууллагын дотоод журам, байгууллагын удирдлагын хуульд нийцсэн шийдвэрийн хэрэгжилт, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах хууль, дүрэм журмыг мөрдүүлэхэд дотоод хяналтын зорилго оршино” гэж үйл ажиллагааг нь тодорхойлсон.

Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, зарцуулалтад хийх дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, хяналтаар илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн даргын баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох өөрчлөлтүүдийг тусгах шаардлагатай байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84,514.4 мянган төгрөгөөр буюу 4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,578.1	60,702.1	55,124.1
Авлага	120,094.4	454.4	(119,640.0)
Бараа материал	93,137.1	131,615.5	38,478.4
Үндсэн хөрөнгө	1,680,956.7	1,791,508.7	110,552.0
Нийт хөрөнгө	1,899,766.3	1,984,280.7	84,514.4
Өр төлбөр	36,743.5	-	(36,743.5)

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,863,022.8	1,984,280.7	121,257.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,899,766.3	1,984,280.7	84,514.4

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдэж, бараа материал, өглөг буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 55,124.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Авлага дансны үлдэгдэл 119,640.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулснаас нөлөөлсөн.
3. Үндсэн хөрөнгө өмнөх оноос 110,552.0 мянган төгрөгөөр нэмэгдэхэд ЭМГазраас 8,268.2 мянган төгрөгийн хөрөнгө, 2 байгууллагаас 48,901.8 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл, Онцгой байдлын ерөнхий газраас 70,000.00 мянган төгрөгийн авто машин хандиваар орлогодож, 8 байгууллагаас 44,664.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, малчдаас 1,200.0 мянган төгрөгийн оффис ширээ хүлээлгэн өгсөн нь нөлөөлсөн байна.
4. Бараа материал өмнөх оноос 38,478.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 160,846.5 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 122,371.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.
5. Өглөг 36,743.5 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагад өгөх эмийн тооцоог төлснөөс шалтгаалсан байна.
6. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 121,257.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилийн үр дүн өссөн нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 389,187.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 64,729.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 34,136.0, нийт зарлагыг 488,052.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 278,317.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд олгох шимтгэл 36,702.2 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 52,861.0 мянган, хангамж, бараа материалын зардал 29,871.9 мянган, нормативт зардал 124,287.3 мянган, эд хогшил худалдан авах зардал 67,952.0 мянган, томилол, зочны зардал 1,500.0 мянга, бараа, үйлчилгээний бусад зардал 6,180.0 мянга, нийт 109,619.9 мянган төгрөгөөр өсгөж 597,671.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төв нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр эрүүл мэндийн даатгалын сангаас 419,048.3 мянган, орон нутгийн төсвөөс 59,561.0 мянган, үйл ажиллагааны орлогоос 120,142.6 мянган төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 468,420.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 59,561.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 588,132.5, мянган төгрөг буюу 98,4 хувьтай байгаа нь цалин хөлсний зардлыг 7,425.7 мянган, нормативт зардлыг 3,305.0 мянган, эд хогшил

худалдан авах зардал 1,324.1 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 1,192.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, байр ашиглалтын зардлыг 1,126.6 мянган, хангамж бараа материалын зардлыг 2,453.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээ 9,539.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөг/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Улсын төсвөөс санхүүжих				
1	80302-Нэг иргэнд ногдох нормативаар	246,515.7	237,331.6	9,184.1	96.3%
2	81603-үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	172,532.6	173,118.2	(585,627.0)	100.3%
3	83603-Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	120,142.6	119,228.0	914,631.0	99.2%
Дүн		539,190.9	529,677.8	338,188.1	98.2%
	Орон нутгийн төсвөөс				
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	58,481.0	58,454.7	26,297.0	100.0%
Дүн		58,481.0	58,454.7	26,297.0	100.0%
Нийт дүн		597,671.9	588,132.5	364,485.1	98.4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 НЭМЭЛТ ТӨСӨВ

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өндөрширээт сумын эрүүл мэндийн төв нь Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 1/318 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн 2-т “Гүйцэтгэлээр санхүүжилт авч буй төсвийн байгууллагууд нэмэлт дансыг ашиглахгүй, хуучин ашиглаж байсан үндсэн дансаар орон нутгийн санхүүжилт авч байгаа тул тус тус дансанд байгаа урьд оны үлдэгдлийг “урьд оны үлдэгдлээс санхүүжих-3000006” ангиллаар үндсэн дансанд шилжүүлж “Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан /83603/” зориулалтын дагуу “Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны зориулалтын дагуу “Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого 120010” ангилалд орлого хуваарилан зарцуулах” гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн дансаар ажил, гүйлгээ гараагүй тул нэмэлт санхүүжилтийн тайлан бэлтгэгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах, төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 1.0 хувиар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны батлагдсан нийт зардлын 598,571.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,987.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,191.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 9,539.4 мянган төгрөгийн зардлын хэмнэлт бий болгосон боловч байр ашиглалттай холбоотой зардлыг 1,126.6 мянган, хангамж бараа материалын зардлыг 2,453.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 159 мэдээлэл байршуулахаас 121 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 33 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5 мэдээллийг байршуулаагүй, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 удаагийн 133,160.5 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 91,565.6 мянган төгрөгөөр буюу 41,594.9 мянган төгрөгөөр дутуу байршуулж, 25 удаагийн орлогын 908,296.9 мянган төгрөг, 32 удаагийн зарлагын 957,647.3 мянган төгрөгийн нийт 1,907,539.1 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Дотоод хяналтын үйл ажиллагаа нь зөвхөн эрүүл мэндийн үндсэн үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно.” заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод аудитын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, холбогдох заавар аргачлалаар хангаж ажиллах зөвлөмж өгөв.

2. Тус байгууллагын оноосон нэр нь улсын бүртгэлийн гэрчилгээнд Төв аймгийн Өндөрширээт сумын Хүн эмнэлэг гэсэн нэрээр бүртгэлтэй байна. Энэ нь байгууллагын дүрэм, хөтлөгдөж буй албан бичиг баримтад Сумын эрүүл мэндийн төв гэсэн нэрээр бүртгэлтэй байна. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т “Сум, тосгоны эрүүл мэндийн төв”, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.” заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын бүртгэлийн гэрчилгээнд тухай бүрд өөрчлөлт оруулж байх зөвлөмж өгөв.

3. Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар

зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НБББББ-ийг стандарт, хууль, тогтоомж, тушаал, заавар, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, баталж мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

4. Худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 7 иргэн, байгууллагын 20,146.8 мянган төгрөгөөр илүү, 28 иргэн, байгууллагын 7,560.1 мянган төгрөгөөр дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлд төлбөрийн цахим баримтгүй ажил гүйлгээ бүртгэхгүй байх зөвлөмж өгөв.

5. Тус эрүүл мэндийн төвийн 2022 оны төсвийн гүйцэтгэл нь төсвийн төсөөллөөс 111,568.2 мянган төгрөгөөр, өмнөх оны гүйцэтгэлээс 204,144.4 мянган төгрөгөөр илүү дүнгээр батлагдсан ба тайлант оны батлагдсан төсвөөс 9,289.4 мянган төгрөгийг хэмнэж, 950,799.5 мянган төгрөгөөр баталж, 908,755.1 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, төрийн сангийн харилцах дансанд 59,282.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 6,475.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 54.5.4-д "Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/;" заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төсөөллийг үндэслэлтэй төлөвлөж байх зөвлөмж өгөв.

6. Шалгагдагч байгууллага нь нийт 92,426.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалтаас 87,500.8 мянган төгрөгийг "Цахим дэлгүүр"-т бүртгэлгүй байгууллагаас худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ.", заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийг "Цахим дэлгүүр"-т бүртгэлтэй байгууллагаас худалдан авч байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Өндөрширээт сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 427,810.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр бүрэн хэрэгжүүлсэн гэж хүргүүлсэн боловч гүйцэтгэлийн үе шатанд шалгахад 80.0 хувийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	454.4	2	454.4	100.0
Албан шаардлага	1	2,421.5	1	2,421.5	100.0
Зөвлөмж	2	424,934.3	1	-	50.0
Нийт дүн	5	427,810.2	4	2,875.9	80.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны хэрэгжилт, өөрийн орлого бүрдүүлэлтийг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 193,212.9 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 9 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав.

Үүнд:

- Тус эмнэлгийн санхүүгийн тайланг тайлагнахдаа улсын төсвийн гүйцэтгэл нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийг нэгтгэж тайлагнаагүй. Нэмэлт санхүүжилтийн тайлант оны 120,331.4 мянган төгрөгийн гүйцэтгэлийг тайлагнаагүйг;
- Санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгээгүй, 6,475.9 мянган төгрөгөөр төсвийн тохируулгын тайланг бэлтгээгүйг;
- Тус байгууллагын цахилгааны зардал нь, төсвийн гүйцэтгэлийн тайлангаас 2,638.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна. Урсгал засварын зардлаас 966.2 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардал хооронд шилжүүлэн бүртгэсэн. Тулган баталгаажуулах захидал, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйг;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд эмчлүүлэгчдийн тоог тайлагнаагүйг;
- Бусад биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 14,194.0 мянган төгрөгийн газарт 2,838.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулсныг;
- Шалгадагч байгууллага нь бусад биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 14,194.0 мянган төгрөгийн газарт 2,838.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулаагүйг;
- Шалгадагч байгууллага нь тайлант жилд 118 нэр төрлийн 17,971.8 мянган төгрөгийн элэгдлийг тооцоогүйг;
- Тайлант оны цалин хөлсний дэлгэрэнгүй тооцооллыг Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай тулган шалгахад 2 ажилтны цалин хөлсийг 4,262.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг;
- Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг ерөнхий журналын цалингийн зардалтай тулган шалгахад 441.4 мянган төгрөгөөр, гарт олгосон мөнгөн дүн 2,144.4 мянган төгрөгөөр, нийт 2,585.8 мянган төгрөгийн зөрүүтэй бүртгэснийг тус тус Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасныг үндэслэн санхүүгийн тайланд залруулсан.

Аудитаар нийт 94,188.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,642.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 63,662.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,177.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

1. Арилжааны банканд 2 харилцах данс нээж 1,420.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.11-т “Банканд данс нээх зөвшөөрлийг төсвийн байгууллагад олгох”, 35 дугаар зүйлийн 35.4-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн байгууллагад данс нээхийг хориглоно”, 35.5-д “Банканд төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн төсвийн байгууллагын дансанд тухайн шатны төрийн сан болон төрийн аудитын байгууллага үзлэг, хяналт хийн, энэ хуулийн 35.3-т заасан зөвшөөрөлгүйгээр нээсэн дансыг хаалгах, хөрөнгийг төрийн сангийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нэгдсэн дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.4-т "Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Нэг ажилтанд орон нутгийн нэмэгдлийг 222.2 мянган төгрөгөөр илүү бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 2-т "Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдлийг дараах албан тушаал эрхэлж байгаа эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно:" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн Төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Эд хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал:

Байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн А/29 дугаар "Эд хөрөнгийн тооллого хийх тухай" тухай тушаалыг хэрэгжүүлээгүй, 63,662.0 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй, тооцоог бодоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-т "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-т "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасны үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Дотоод хяналт, шалгалттай холбоотой асуудал:

Төв аймгийн НДХ-ийн хяналт шалгалт дотоод аудитын тасгаас хийсэн хяналт шалгалтаар 2,247.8 мянган төгрөгийн нөхөн шимтгэл, 674.4 мянган төгрөгийн алданги нийт 2,922.2 мянган төгрөгийн төлбөрийн акт бичигдсэнээс 1,744.4 мянган төгрөгийг шилжүүлж, 1,177.8 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэж тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг аккрузл сууриар бүртгэж байх зөвлөмж өгөв.

2. Удирдлага, зохион байгуулалттай холбоотой асуудал:

Эрүүл мэндийн төвийн даргыг 2022 оны 2, 4, 7 саруудад 3 удаа чөлөөлж томилсон, ахлах нягтлан бодогч нь 12 дугаар сард үүрэг ажлаа орхиж явсан. Энэ нь эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг жигд явуулахад сөргөөр нөлөөлж байна.

Шийдвэрлэсэн нь: Удирдлагыг тогтвор суурьшилтай ажиллуулах арга хэмжээг авч ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус эмнэлгийн санхүүгийн тайланг тайлагнахдаа улсын төсвийн гүйцэтгэл нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийг нэгтгэж тайлагнаагүй. Нэмэлт санхүүжилтийн тайлант оны 120,331.4 мянган төгрөгийн гүйцэтгэлийг тайлагнаагүй.	1	120,331.4	-	-	1	120,331.4	1	120,331.4	-	-	-	-
Санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгээгүй, 6,475.9 мянган төгрөгөөр төсвийн тохируулгын тайланг бэлтгээгүй байна.	1	6,475.9	-	-	1	6,475.9	1	6,475.9	-	-	-	-
Тус байгууллагын цахилгааны зардал нь, төвийн гүйцэтгэлийн тайлангаас 2,638.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна. Урсгал засварын зардлаас 966.2 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардал хооронд шилжүүлэн бүртгэсэн .Тулган баталгаажуулах захидал, тооцоо нийлсэн акт ирүүлээгүй.	1	3,604.6	-	-	1	3,604.6	1	3,604.6	-	-	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайланд эмчлүүлэгчдийн тоог тайлагнаагүй байна.	1	-	-	-	1	-	1	-	-	-	-	-
Шалгагдагч байгууллага нь бусад биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 14,194.0 мянган төгрөгийн газарт 2,838.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.	1	2,838.8	-	-	1	2,838.8	1	2,838.8	-	-	-	-
Шалгагдагч байгууллага нь тайлант жилд 118 нэр төрлийн 17,971.8 мянган төгрөгийн элэгдлийг тооцоогүй байна.	1	17,971.8	-	-	1	17,971.8	1	17,971.8	-	-	-	-
Тайлант оны цалин хөлсний дэлгэрэнгүй тооцооллыг Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай тулган шалгахад 2 ажилтны цалин хөлсийг 4,262.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.	1	4,262.8	-	-	1	4,262.8	1	4,262.8	-	-	-	-

Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг ерөнхий журналын цалингийн зардалтай тулган шалгахад 441.4 мянган төгрөгөөр, гарт олгосон мөнгөн дүн 2,144.4 мянган төгрөгөөр, нийт 2,585.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	2,585.8	-	-	1	2,585.8	1	2,585.8	-	-	-	-
Тус байгууллагын халаалтын зардлыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын нэхэмжлэхтэй тулган шалгахад 4,126.1 мянган төгрөгөөр, төсвийн гүйцэтгэлийн тайлангаас 28,180.6 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнагдсан байна. Урсгал засварын зардлаас 2,835.1 мянган төгрөгийг халаалтын зардал хооронд шилжүүлэн бүртгэсэн Тулган баталгаажуулах захидал, тооцоо нийлсэн акт ирүүлээгүй.	1	35,141.9	-	-	1	35,141.9	1	35,141.9	-	-	-	-
Дүн	9	193,212.9		-	9	193,212.9	9	193,212.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төв аймгийн НДХ-ийн хяналт шалгалт дотоод аудитын тасгаас хийсэн хяналт шалгалтаар 2,247.8 мянган төгрөгийн нөхөн шимтгэл, 674.4 мянган төгрөгийн алданги нийт 2,922.2 мянган төгрөгийн төлбөрийн акт бичигдсэнээс 1,744.4 мянган төгрөгийг шилжүүлж, 1,177.8 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэж тайлагнаагүй байна.	1	1,177.8	-	-	-	-	1	1,177.8	-	-	-	-
Байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн А/29 дугаар "Эд хөрөнгийн тооллого хийх тухай" тухай тушаалыг хэрэгжүүлээгүй, 63,662.0 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй, тооцоог бодоогүй байна.	1	63,662.0	-	-	1	63,662.0	-	-	-	-	-	-
Эрүүл мэндийн төвийн даргыг 2022 оны 2,4,7 саруудад 3 удаа чөлөөлж томилсон, ахлах нягтлан бодогч нь мөн оны 12 дугаар сард үүрэг ажлаа орхиж явсан. Энэ нь эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг жигд явуулахад сөргөөр нөлөөлж байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Тус байгууллага нь арилжааны банканд /ХААН банканд 5743080010-Касс, 5743118365-Түрээслэгчийн мөнгө, 5743001195-эмийн эргэлтийн сан/3 харилцах дантай байна./	1	1,420.0	1	1,420.0	-	-	-	-	-	-	-	-

Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийг давтан тооцоолоход нэг ажилтанд орон нутгийн нэмэгдлийг 222.2 мянган төгрөгөөр илүү бодож олгосон байна.	1	222.2	1	222.2	-	-	-	-	-	-	-	-
Дүн	5	66,481.9	2	1,642.2	1	63,662.0	2	1,177.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 159 мэдээлэл байршуулахаас 121 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 33 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, 5 мэдээллийг байршуулаагүй, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 удаагийн 133,160.5 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 91,565.6 мянган төгрөгөөр буюу 41,594.9 мянган төгрөгөөр дутуу байршуулж, 25 удаагийн орлогын 908,296.9 мянган төгрөг, 32 удаагийн зарлагын 957,647.3 мянган төгрөгийн нийт 1,907,539.1 мянган төгрөгийн гүйлгээг байршуулаагүй байна.	1	1,907,539.1	-	-	1	1,907,539.1	-	-
Дүн	1	1,907,539.1	-	-	1	1,907,539.1	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн эрүүл мэндийн үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Тус байгууллагын оноосон нэр нь улсын бүртгэлийн гэрчилгээнд Төв аймгийн Өндөрширээт сумын Хүн эмнэлэг гэсэн нэрээр бүртгэлтэй байна. Энэ нь байгууллагын дүрэм, хөтлөгдөж буй албан бичиг баримтад Сумын эрүүл мэндийн төв гэсэн нэрээр бүртгэлтэй байна.	1	-	-	-	-	-	1	-
Байгууллага нь өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн НБББББ-гүй байна.	1	-	-	-	-	-	1	-

Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 7 иргэн, байгууллагын 20,146.8 мянган төгрөгөөр илүү, 28 иргэн, байгууллагын 7,560.1 мянган төгрөгөөр дутуу байна.	1	27,706.96	-	-			1	27,707.0
Тус эрүүл мэндийн төвийн 2022 оны төсвийн гүйцэтгэл нь төсвийн төсөөллөөс 111,568.2 мянган төгрөгөөр, өмнөх оны гүйцэтгэлээс 204,144.4 мянган төгрөгөөр илүү дүнгээр батлагдсан ба тайлант оны батлагдсан төсвөөс 9,289,387.05 төгрөгийг хэмнэж, 950,799.5 мянган төгрөгөөр баталж, 908,755.1 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, төрийн сангийн харилцах дансанд 59,282.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 6,475.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.	1	65,758.05	-	-	-		1	65,758.1
Шалгагдагч байгууллага нь нийт 92,426.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалтаас 87,500.8 мянган төгрөгийг "Цахим дэлгүүр"-т бүртгэлгүй байгууллагаас худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ." гэж заасныг зөрчсөн байна	1	87,500.80	-	-	-	-	1	87,500.8
Дүн	6	180,965.8	-	-	-	-	6	180,965.8
Нийт дүн	7	2,088,504.91	-	-	1	1,907,539.10	6	180,965.81